



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

Нэмэлт хувьцаа гаргах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “2022-2023 онд биржээр төрийн мэдлийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хавсралтад дурдсан төрийн өмчит хуулийн этгээдүүдэд үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт хувьцааг гаргаж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгосугай.

2.Компанийн үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжихтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулах асуудлыг Үнэт цаасны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт зөвшөөрсүгэй.

3.Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн нэмэлт хувьцааг гаргах, хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид зөвлөсүгэй.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002545

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2022 оны .07 дугаар сарын .05  
өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт

**НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАЖ, ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ АРИЛЖИХ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хуулийн этгээдийн нэр	Олон нийтэд нээлттэй худалдах хувь	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Компанийн Гүйцэтгэх захирал
1	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК	34 хүртэлх хувь	Б.Сүх-Очир /СЯ/	Х.Алтай
2	"Монголын цахилгаан холбоо" ХК	34 хүртэлх хувь	Т.Лхагвасүрэн /ТӨБЗГ/	Б.Чинбат
3	"Үндэсний давхар даатгал" ХК	34 хүртэлх хувь	З.Энхболд /СЯ/	Б.Жавхлант
4	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК	34 хүртэлх хувь	Ц.Эрдэнэбаяр /АМГТГ/	Б.Мөнхбат
5	"Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ	34 хүртэлх хувь		Э.Цогтгэрэл
6	"Баянчандмань АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Ч.Ренчиндамба /ЗТХЯ/	Б.Мөнхбаяр
7	"Налайх АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Ч.Ренчиндамба /ЗТХЯ/	Ц.Баттулга
8	"Архангай АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Н.Сугаржав /ЗТХЯ/	Ю.Ганзориг
9	"Багануур АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Д.Загдраднаа /ЗТХЯ/	А.Алтангадас
10	"Булган АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	В.Дарханбаатар /ТӨБЗГ/	Э.Пүрэвдэмбэрэл
11	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Ц.Түвшинзаяа /ТӨБЗГ/	Б.Алтанхуяг
12	"Дархан АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	М.Энхболд /ЗТХЯ/	Б.Баясгалан
13	"Дорноговь АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Д.Загдраднаа /ЗТХЯ/	Д.Мөнх-Эрдэнэ
14	"Завхан АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Ц.Түвшинзаяа /ТӨБЗГ/	Г.Баттулга
15	"Орхон АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	В.Дарханбаатар /ТӨБЗГ/	Ц.Батзориг
16	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Н.Сугаржав /ЗТХЯ/	Д.Лхам-Оролмаа
17	"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	М.Энхболд /ЗТХЯ/	М.Батболд
18	"Талын зам" ТӨХК	34 хүртэлх хувь	Д.Гэрэлням /ЗТХЯ/	Б.Түвшинмөнх
19	"Төв АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Н.Бат-Эрдэнэ /ЗТХЯ/	Д.Болдбаатар
20	"Увс АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Ц.Түвшинзаяа /ТӨБЗГ/	Р.Төмөрчөдөр
21	"Харгуй" ТӨХК	34 хүртэлх хувь	Д.Гэрэлням /ЗТХЯ/	Л.Бат-Октябрь
22	"Хархорин АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Н.Сугаржав /ЗТХЯ/	Ж.Бадрах
23	"Ховд АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Ц.Түвшинзаяа /ТӨБЗГ/	Н.Батцагаан
24	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	В.Дарханбаатар /ТӨБЗГ/	Б.Галбадрах
25	"Эрдэнэсант АЗЗА" ТӨХК	34 хүртэлх хувь	Н.Бат-Эрдэнэ /ЗТХЯ/	Д.Баатар